



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/05

Сүхбаатар сум

### Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", Биеийн тамир спортын тухай хуулийн 8.1.1, 8.1.2, 8.1.3, 24.2, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.9 дэх зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн аварга шалгаруулах шагайн "Отго харваа 2019" тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсүгэй.
2. Дэмжлэгт зарцуулагдах 480000 /дөрвөн зуун наян мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.
3. Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг аймгийн Шагайн холбооны тэргүүн /Т.Гантулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын  
2020 оны 01 дугаар сарын 09-ны өдрийн  
А/ОС дугаар захирамжийн хавсралт



**АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ШАГАЙН “ОТГО ХАРВАА 2019”  
ТЭМЦЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

№	Зардлын нэр	Байр	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Мөнгөн шагнал баг	1-р байр	120.000	120.000
		2-р байр	100.000	100.000
		3-р байр	80.000	80.000
2	Мөнгөн шагнал ганцаарчилсан	1-р байр	40.000	40.000
		2-р байр	30.000	30.000
		3-р байр	15.000	15.000
Нийт дүн				<b>480.000</b>

Төсөв зохиосон:

Э.Оюун-Эрдэнэ  
/АЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн/

Төсөв хянасан:

З.Загдсүрэн  
/АЗДТГ-ын нягтлан бодогч/